



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ОРА-2021/8/СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг

2021 он

Орхон аймаг дахь төрийн аудитын газрын захирал бөгөөд  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70359826 Цахим хаяг: [orkhon@audit.gov.mn](mailto:orkhon@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: [erdeneb@audit.gov.mn](mailto:erdeneb@audit.gov.mn)

Аудитор: Д.Мягмарсүрэн

Утас: 99030170 Цахим хаяг: [www.dalaivanaudit.mn](http://www.dalaivanaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан татвар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
БОАЖГ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын газар

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
3.Аудитын тайлан .....	10
3.1. Ерөнхий зүйл .....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	15
4. Менежментийн захидал .....	15

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.25 № 02  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ОРХОН АЙМГИЙН УНАГА  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Б.ОЮУНБАЙГАЛЬ ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>61,297,755.00</b>	<b>56,935,724.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	5,000.00	1,325,979.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,320,979.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	5,000.00	5,000.00
3351	Байгууллагаас авах авлага	5,000.00	5,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	61,292,755.00	55,609,745.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	52,574,945.00	53,935,645.00
35110	Тусгай зориулалттай материал	52,574,945.00	53,935,645.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	8,717,810.00	1,674,100.00
35410	Бичиг хэргийн материал	-	134,500.00
35420	Аж ахуйн материал	2,708,510.00	732,500.00
35460	Хүнсний материал	-	410,100.00
35470	Бусад хангамжийн материал	5,895,300.00	397,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,138,322,542.90</b>	<b>2,141,713,011.16</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,138,322,542.90	2,141,713,011.16
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,827,874,209.65	1,831,558,011.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,758,869,959.53	1,810,199,959.53
39202	Хуримтлагдсан элэгдэл	(39,735,858.48)	(79,471,716.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	41,033,800.00	49,467,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(15,677,800.31)	(22,286,241.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	110,650,180.00	110,950,180.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,266,071.09)	(37,301,469.73)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	310,448,333.25	310,155,000.08
39301	Программ хангамж	1,230,000.00	1,230,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(661,666.75)	(954,999.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	309,880,000.00	309,880,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,199,620,297.90</b>	<b>2,198,648,735.16</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>800.00</b>	<b>1,320,979.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	800.00	1,320,979.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	800.00	1,320,979.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,320,979.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,199,619,497.90</b>	<b>2,197,327,756.16</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,199,619,497.90	2,197,327,756.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	309,880,000.00	309,880,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,016,648,450.97	1,014,356,709.23
51210	Өмнөх үеийн үр дүн	1,016,648,450.97	1,016,648,450.97
51220	Тайлант үеийн үр дүн	-	(2,291,741.74)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	873,091,046.93	873,091,046.93
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,199,620,297.90</b>	<b>2,198,648,735.16</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>549,086,725.00</b>	<b>618,324,000.00</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>13,809,800.00</b>	<b>64,145,100.00</b>
Нийтлэг татварын бус орлого	13,809,800.00	64,145,100.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	13,809,800.00	64,145,100.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,809,800.00	64,145,100.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>535,276,925.00</b>	<b>554,178,900.00</b>
Улсын төвлөрсөн төсвөөс	448,473,300.00	509,841,500.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	448,473,300.00	509,841,500.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,430,700.00	44,337,400.00

Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,430,700.00	44,337,400.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>596,559,048.59</b>	<b>616,525,853.74</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>596,559,048.59</b>	<b>616,525,853.74</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	596,128,425.26	601,121,786.02
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	370,861,302.00	417,908,338.30
Үндсэн цалин	292,924,442.00	274,127,199.12
Нэмэгдэл	42,187,344.00	102,802,467.39
Унаа хоолны хөнгөлөлт	1,680,000.00	1,586,000.00
Урамшуулал	34,069,516.00	39,392,671.79
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	46,373,809.37	51,781,962.87
Тэтгэврийн даатгал	32,032,844.35	35,608,814.67
Тэтгэмжийн даатгал	3,898,357.07	4,393,452.18
ҮОМШӨ-ний даатгал	2,948,445.47	3,344,697.38
Ажилгүйдлийн даатгал	681,287.50	766,817.98
Эрүүл мэндийн даатгал	6,812,874.98	7,668,180.66
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,968,948.24	28,099,755.11
Гэрэл, цахилгаан	6,375,561.00	3,672,510.87
Түлш, халаалт	17,310,491.39	18,439,977.15
Цэвэр, бохир ус	7,282,895.85	5,987,267.09
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,623,290.00	15,698,750.00
Бичиг хэрэг	712,750.00	108,100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	317,870.00	143,600.00
Ном, хэвлэл	-	50,000.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	279,870.00	8,275,850.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,741,810.00	7,121,200.00
<b>Нормативт зардал</b>	75,985,805.00	22,853,448.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	70,700.00	196,900.00
Хоол, хүнс	75,825,105.00	22,614,548.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	90,000.00	42,000.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,292,700.00	2,193,900.00
Урсгал засвар	2,292,700.00	2,193,900.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	910,000.00	1,307,300.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	299,300.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	610,000.00	1,008,000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	59,112,570.65	61,278,331.74
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,506,500.00	4,605,300.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,465,670.65	56,673,031.74
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	430,623.33	15,404,067.72
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	400,000.00	50,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	50,000.00
<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	51.76	14,157,744.89
Төвлөрүүлэх шилжүүлэг	51.76	14,157,744.89
<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	30,571.57	1,196,322.83
Төвлөрүүлэх шилжүүлэг	30,571.57	1,196,322.83
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(47,472,323.59)</b>	<b>1,798,146.26</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	4,089,888.00
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	2,908,510.00
Үнэ төлбөргүй гарсан зардал	-	1,181,378.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(4,089,888.00)
<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(47,472,323.59)</b>	<b>(2,291,741.74)</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>539,890,243.00</b>	<b>564,593,430.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>539,890,243.00</b>	<b>564,593,430.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	448,473,300.00	509,841,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	448,473,300.00	509,841,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	33,430,700.00	44,337,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,430,700.00	44,337,400.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	4,613,318.00	10,414,530.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,613,318.00	10,414,530.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>539,340,243.00</b>	<b>564,593,430.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>539,340,243.00</b>	<b>564,593,430.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>534,296,301.67</b>	<b>538,774,832.28</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	370,856,499.92	417,908,338.30
210101	Үндсэн цалин	312,532,904.60	274,127,199.12
210102	Нэмэгдэл	39,688,879.32	102,802,467.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	1,586,000.00
210104	Урамшуулал	18,634,716.00	39,392,671.79
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	45,973,728.51	51,781,962.87
210201	Тэтгэврийн даатгал	32,950,107.39	35,608,814.67
210202	Тэтгэмжийн даатгал	3,255,930.28	4,393,452.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,604,744.22	3,344,697.38
210204	Ажилгүйдлийн даатгал	651,186.06	766,817.98
210205	Эрүүл мэндийн даатгал	6,511,760.56	7,668,180.66
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,968,948.24	28,099,755.11
210301	Гэрэл, цахилгаан	6,375,561.00	3,672,510.87
210302	Түлш, халаалт	17,310,491.39	18,439,977.15
210303	Цэвэр, бохир ус	7,282,895.85	5,987,267.09
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,593,000.00	9,294,550.00
210401	Бичиг хэрэг	791,550.00	108,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	317,870.00	143,600.00
210404	Ном, хэвлэл	-	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	279,070.00	8,673,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	204,510.00	319,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	78,842,325.00	25,185,726.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	51,000.00	196,900.00
210502	Хоол, хүнс	74,431,325.00	24,206,026.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,360,000.00	782,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,411,700.00	2,079,900.00
210604	Урсгал засвар	2,411,700.00	2,079,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	910,000.00	1,307,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	299,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	610,000.00	1,008,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,740,100.00	3,117,300.00



210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,599,700.00	3,117,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,043,941.33</b>	<b>25,818,597.72</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,013,318.00	10,464,530.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,613,318.00	10,414,530.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	50,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	51.76	14,157,744.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	51.76	14,157,744.89
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	30,571.57	1,196,322.83
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,571.57	1,196,322.83

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	309,880,000.00	873,091,046.93	1,064,120,774.56	2,247,091,821.49
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	309,880,000.00	873,091,046.93	1,064,120,774.56	2,247,091,821.49
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(47,472,323.59)	(47,472,323.59)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	309,880,000.00	873,091,046.93	1,016,648,450.97	2,199,619,497.90
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	309,880,000.00	873,091,046.93	1,016,648,450.97	2,199,619,497.90
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	309,880,000.00	873,091,046.93	1,016,648,450.97	2,199,619,497.90
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,291,741.74)	(2,291,741.74)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	309,880,000.00	873,091,046.93	1,014,356,709.23	2,197,327,756.16

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны	
		Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	539,859,619.67	554,178,900.00	538,824,832.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	539,309,619.67	554,178,900.00	538,824,832.28
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	534,296,301.67	554,128,900.00	538,774,832.28
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	370,856,499.92	417,908,400.00	417,908,338.30
210101	Үндсэн цалин	312,532,904.60	266,184,500.00	274,127,199.12
210102	Нэмэгдэл	39,688,879.32	114,895,500.00	102,802,467.39

Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,200,000.00	1,586,000.00
210104	Урамшуулал	18,634,716.00	33,628,400.00	39,392,671.79
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	45,973,728.51	51,782,100.00	51,781,962.87
210201	Тэтгэврийн даатгал	32,950,107.39	35,217,800.00	35,608,814.67
210202	Тэтгэмжийн даатгал	3,255,930.28	4,141,100.00	4,393,452.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,604,744.22	3,312,900.00	3,344,697.38
210204	Ажилгүйдлийн даатгал	651,186.06	828,200.00	766,817.98
210205	Эрүүл мэндийн даатгал	6,511,760.56	8,282,100.00	7,668,180.66
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,968,948.24	42,257,500.00	28,099,755.11
210301	Гэрэл, цахилгаан	6,375,561.00	6,065,600.00	3,672,510.87
210302	Түлш, халаалт	17,310,491.39	24,993,400.00	18,439,977.15
210303	Цэвэр, бохир ус	7,282,895.85	11,198,500.00	5,987,267.09
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,593,000.00	9,529,800.00	9,294,550.00
210401	Бичиг хэрэг	791,550.00	177,300.00	108,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	317,870.00	143,600.00	143,600.00
210404	Ном, хэвлэл	-	110,900.00	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	279,070.00	8,778,800.00	8,673,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	204,510.00	319,200.00	319,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	78,842,325.00	25,381,600.00	25,185,726.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	51,000.00	196,900.00	196,900.00
210502	Хоол, хүнс	74,431,325.00	24,206,100.00	24,206,026.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,360,000.00	978,600.00	782,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,411,700.00	2,079,900.00	2,079,900.00
210604	Урсгал засвар	2,411,700.00	2,079,900.00	2,079,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	910,000.00	1,329,300.00	1,307,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	321,300.00	299,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	610,000.00	1,008,000.00	1,008,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,740,100.00	3,679,100.00	3,117,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,599,700.00	3,117,300.00	3,117,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,013,318.00	50,000.00	50,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,013,318.00	50,000.00	50,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	50,000.00	50,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	486,517,318.00	554,178,900.00	554,178,900.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	448,473,300.00	509,841,500.00	509,841,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	448,473,300.00	509,841,500.00	509,841,500.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	33,430,700.00	44,337,400.00	44,337,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	33,430,700.00	44,337,400.00	44,337,400.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Унага цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тус газрын эрхлэгч Б.Оюунбайгаль танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 10-наас 2021 оны 02 дугаар сарын 16-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК Орхон аймаг дахь салбарын захирал Д.Мягмарсүрэн, аудитор Б.Пүрэвсүрэн, туслах аудитор Б.Энхжин нар Орхон аймгийн төрийн аудитын газрын захиалгаар хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймгийн төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Байгууллагын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Орхон аймгийн Унага цэцэрлэг нь “Хөдөлгөөн эрүүл мэндийн эрхэмлэн хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2020 оны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд гарсан онцлог өөрчлөлт, шинэчлэлт байхгүй.

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Орхон аймгийн Унага цэцэрлэг нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Орхон аймгийн Унага цэцэрлэгийн байгууллагын дотоод хяналтын комисс нь 2020 онд Боловсрол, Эрүүл ахуй халдвар хамгаалал, Хүнсний аюулгүй байдал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Санхүү өмчийн бүртгэл тооцоо гэсэн 5 чиглэлээр хяналт шалгалт явуулж, алдаа зөрчил гаргасан ажилчдад сануулга өгч, засаж залруулах үүрэг даалгавар өгөн ажилласан байна. Санхүү, нярвын үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар шилэн дансны мэдээллийг хугацаанд нь оруулсан, нийгмийн даатгалын дэвтэр хөтлөлт 5 хүнийх дутуу бөглөгдсөн байсныг залруулсан, цалингийн шифрийг ажилтан бүрийн и-мэйл хаягаар хугацаанд нь явуулж байх, бараа материалын орлого зарлагын гүйлгээг тухай бүрд хийж, санхүүгийн программ болон бодит үлдэгдлийг тулгаж байх гэсэн зөвлөмжүүдийг өгсөн байна.

Орхон аймгийн Унага цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт орлогын 325,705.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,257.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 618,324.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,183.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 971.56 мянган төгрөгөөр буюу 0.04 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	5.00	1,325.98	1,320.98
Урьдчилгаа	0.00	0.00	0.00
Бараа материал	61,292.76	55,609.75	(5,683.01)
Үндсэн хөрөнгө	2,138,322.54	2,141,713.01	3,390.47

<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,199,620.30</b>	<b>2,198,648.74</b>	<b>(971.56)</b>
Өр төлбөр	0.80	1,320.98	1,320.18
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,199,619.50	2,197,327.76	(2,291.74)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,199,620.30</b>	<b>2,198,648.74</b>	<b>(971.56)</b>

Авлага дансны үлдэгдэл 1,325.98 мянган төгрөг болж өссөн нь хөгжлийн бэрхшээлтэй ажилчдаас суутган тооцсон ХХОАТ-ын 1,320.98 мянган төгрөгийн татварын авлагаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 55,609.75 мянган төгрөг болж 5,683.01 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд худалдан авалтаар 37,968.2 мянган төгрөг, 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр Баян-Өндөр сумаас үнэ төлбөргүй хүлээн авсан 819.9 мянган төгрөгийн тоглоом, эцэг эхчүүдээс хүүхдийн хэрэгцээнд зориулан авсан 7,452.0 мянган төгрөгийн бараа материалаар нэмэгдэж, зарцуулалтаар 47,833.2 мянган төгрөгийн бараа материал буурч, ковидтой холбогдуулан 1,181.3 мянган төгрөгийн хүнсний материалыг онцгой байдлын газарт үнэ төлбөргүй шилжүүлж, байгууллагын даргын 2020 оны 05-р сарын 15-ны өдрийн 06 тоот тушаалыг үндэслэн 2,908.5 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,141,713.01 мянган төгрөг болж 3,390.47 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн данс нь 2018 онд багш, ажиллагсад, эцэг эхийн хандив дэмжлэгээр нийлүүлэгдсэн 900.0 төгрөгийн буйдан, тоног төхөөрөмж, 2019 онд ЗДТГ-ийн БОАЖГ-ын хандиваар нийлүүлэгдсэн 2,585.0 мянган төгрөгийн цахилгаан халаагуур, 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдөр “Багш бүрийг компьютержуулах” хөтөлбөрийн хүрээнд үнэ төлбөргүй хүлээн авсан 5,248.5 мянган төгрөгийн компьютер, 2020 оны 10 дугаар сарын 14-ны өдөр аймгийн болзошгүй аваарын зардлаар хийгдсэн 51,330.0 мянган төгрөгийн өртөгтэй засварын ажил хийснээс шалтгаалжээ.

Өглөг дансны үлдэгдэл 1,320.98 мянган төгрөг болж өссөн нь хөгжлийн бэрхшээлтэй ажилчдаас суутгасан цалингийн өглөгөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,197,327.76 мянган төгрөг болж 2,291.74 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Орхон аймгийн Унага цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 69,237.28 мянган төгрөгөөр буюу 12.6 хувиар өссөн байна. Тайлант хугацаанд материаллаг өөрчлөлт гарсан нь засаг даргын захирамжаар цахилгаан халаагуур болон дотор халаалтын шугамын засварын ажлыг үнэ төлбөргүй хүлээн авч орлогод бүртгэсэн, ковидтой холбогдуулан үйл ажиллагаа зогссон тул нэмэлт санхүүжилт төвлөрүүлээгүй байна.

*Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого*

/мянган төгрөг/

	2019.12.31	2020.12.31	Зөрүү
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,809.80	64,145.10	50,335.30
Улсын төвлөрсөн төсвөөс санхүүжих	448,473.30	509,841.50	61,368.20
Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,430.70	44,337.40	10,906.70
Нэмэлт санхүүжилтийн орлого	53,372.92		(53,372.92)
<b>Нийт дүн</b>	<b>549,086.73</b>	<b>618,324.00</b>	<b>69,237.28</b>

Нийт зардал өмнөх оноос 4,993.3 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн байна. Тайлант хугацаанд материаллаг өөрчлөлт гарсан нь ажиллах орон тоо нэмэгдсэнээс

цалингийн зардал нэмэгдэж, ковидтой холбоотой цэцэрлэг сургуулийн үйл ажиллагаа хаагдсан тул норматив зардал буурсан байна.

*Хүснэгт 3. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал*

/мянган төгрөг/

	2019.12.31	2020.12.31	Зөрүү
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	370,861.30	417,908.34	47,047.04
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,373.81	51,781.96	5,408.15
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,968.95	28,099.76	(2,869.19)
Хангамж, бараа материалын зардал	9,623.29	15,698.75	6,075.46
Нормативт зардал	75,985.81	22,853.45	(53,132.36)
Эд хогшил, урсгал засварын зардал	2,292.70	2,193.90	(98.80)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	910.00	1,307.30	397.30
Бараа үйлчилгээний бусад зардал	59,112.57	61,278.33	2,165.76
<b>Нийт дүн</b>	<b>596,128.43</b>	<b>601,121.79</b>	<b>4,993.36</b>

**3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 554,178.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 538,774.8 мянган төгрөг буюу 97.23 хувьтай байгаа нь Ковидтой холбоотой хөл хорионы үеэр цэцэрлэгүүд цахимаар хичээллэсэн тул байр, ашиглалтын зардал багасаж хэмнэлт үүссэнээс шалтгаалжээ.

Тайлант хугацаанд 15,354.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

**3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 137 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 1 мэдээлэл, иж бүрэн бус мэдээлсэн 2 мэдээлэл байна. Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус байгууллагын шилэн дансанд хийсэн дотоод аудитын тайлангаар 28.1 сая төгрөгийн худалдан авалт, 64.0 сая төгрөгийн тушаалыг дутуу мэдээлсэн байсныг залруулж нөхөж мэдээлсэн байна.

**3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тухайн байгууллага нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлангаар 1 албан шаардлага, 2 зөвлөмж авсан ба биелэлтийг 2020 оны 06-р сарын 22-ны өдрийн 32 тоот хариу тайлбар ирүүлэн ажилласан байна.

- Өмнөх тайлант онд бараа материалын тайлан нь анхан шатны баримтын бүрдэл дутуу, ойлгомжгүй, замбараагүй байсан зөрчил илэрснийг залруулж бараа материалын бүртгэл хөтлөлтийг сайжруулсан байна.
- Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тодруулгыг зохих журмын дагуу бэлтгээгүй зөрчил илэрсэн ба 2020 онд санхүүгийн тайлан, тодруулгыг зохих журмын дагуу бэлтгэн ирүүлж зөвлөмжийг 100% хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 142,221.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 42,049.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,104.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 96,067.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бараа материалын тайлангаар 2,708.5 мянган төгрөгийн тусгай зориулалтын материалыг аж ахуйн материалд орлогдсон мөн 42,049.82 мянган төгрөгийн бараа материалын орлого зарлагын гүйлгээ нь зардал хооронд гүйсэн байсныг аудитын явцад залруулга хийсэн.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Нийт ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосноос гадна 2020 оны 12-р сард цалингийн зардлын хэмнэлтээс бүх ажилтнуудад тэнцүү 108,100.0 төгрөг буюу нийт 4,104,000.0 төгрөгийг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төрийн албаны тухай хуулийн 51.2-д “Энэ хуулийн 51.1.1-д заасан шагнал олгох, 51.1.3-т заасан шагналд тодорхойлох болон 51.1.4-т заасан мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар, ... батална”, 57.8-д “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлсний доод хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно” гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.4, 4.5 дахь заалт, 2018 оны 382-р тогтоолын 2-д “Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн жилд бараа материалын орлого зарлагын гүйлгээг зохих дансанд бүртгэж буй эсэх дээр анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### ***Зардлын данстай холбоотой асуудал***

1. ***Илрүүлэлт:*** Хөгжлийн бэрхшээлтэй хоёр ажилтны цалинг тооцохдоо 1-12 сард 1,320.9 мянган төгрөгийн ХХОАТ илүү суутгасан байна.
2. ***Эрсдэл:*** Цалингийн тооцооллыг буруу хийх, илүү дутуу олгох.
3. ***Өгсөн зөвлөмж:*** Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1.2-т "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлнө" гэсэн заалтын дагуу татварыг чөлөөлж тооцох.
4. ***Байгууллагаас өгсөн харуу тайлбар:*** Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 08 тоот албан бичгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

##### ***Балансын данстай холбоотой асуудал***

1. ***Илрүүлэлт:*** Тайлангийн хугацааны эцэст 1,325.9 мянган төгрөгийн авлага, 1,320.9 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.
2. ***Эрсдэл:*** Найдваргүй авлага үүсэх.
3. ***Өгсөн зөвлөмж:*** Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх" гэсэн заалтыг биелүүлж ажиллах.
4. ***Байгууллагаас өгсөн харуу тайлбар:*** Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 08 тоот албан бичгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

##### ***Балансын данстай холбоотой асуудал***

1. ***Илрүүлэлт:*** Тайлант хугацаанд оруулбал зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 137 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 3 мэдээлэл, иж бүрэн бус мэдээлсэн 2 мэдээлэл байна. Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус байгууллагын шилэн дансанд хийсэн дотоод аудитын тайлангаар 28.1 сая төгрөгийн худалдан авалт, 64.0 сая төгрөгийн тушаалыг дутуу мэдээлсэн байсныг залруулж нөхөж мэдээлсэн байна.
2. ***Эрсдэл:*** Шилэн дансны мэдээллийн ил тод байдал алдагдах.



Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3. Өвсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.2-т "Төсвийн байгууллага дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ" гэсэн заалтуудыг дагаж мөрдөж, мэдээллийг цаг хугацаандаа, үнэн зөв, иж бүрэн мэдээлж хэвших.

4. Байгууллагаас өвсөн харилу тайлбар: Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 08 тоот албан бичгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

Бэлтгэсэн:			
Аудитор		Б.Пүрэвсүрэн	Огноо
Анхан шатанд хянасан:			
Аудитын менежер		Б.Эрдэнэ	Огноо
Хоёр дахь шатанд хянасан:			
Эрхлэгч, тэргүүлэх аудитор		Ц.Нармандах	Огноо

